



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/211

Улаанбаатар хот

Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн
чиглэлийн хөтөлбөрөөр оюутан элсүүлэхэд
зохицуулалт хийх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн 2024-2025 оны хичээлийн жилд тэргүүлэх, эрэлттэй мэргэжлийн чиглэлээр оюутан элсүүлэх үйл ажиллагааг дэмжих зорилгоор ТУШААХ нь:


1. Тэргүүлэх, эрэлттэй мэргэжлийн чиглэлд заасан хөтөлбөр болон мэргэжлийн чиглэл (хөтөлбөрийн нэр) 05-09-д заасан ерөнхий чиглэлд хамаарах хөтөлбөрөөр элсэгчийн Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны "Босго оноо тогтоох тухай" А/170 дугаар тушаалын хавсралт дахь "Элсэлтийн шалгалт-1"-д заасан хоёр судлагдахууны онооны аль нэгийг "Элсэлтийн шалгалт-2"-т заасан аль нэг судлагдахуун, харгалзах оноонд шилжүүлэн тооцож болно.

2. Тэргүүлэх, эрэлттэй мэргэжлийн чиглэлд заасан хөтөлбөр болон мэргэжлийн чиглэл (хөтөлбөрийн нэр) 05-09-д заасан ерөнхий чиглэлд хамаарах хөтөлбөрөөр элсэгчийн ур чадварын шалгалтын оноог энэхүү тушаалын 1-д дурдсан тушаалын хавсралт дахь "Элсэлтийн шалгалт-2"-т заасан судлагдахууны 480 ба түүнээс дээш оноогоор дүйцүүлэн тооцож болно.

3. Дээд боловсролын сургалтын байгууллагад 2024-2025 оны хичээлийн жилд шинээр элсэгчдийг энэхүү тушаалд заасны дагуу дээд боловсролын удирдлага мэдээллийн системд бүртгэх арга хэмжээ авахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Н.Нарангэрэл)-т даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

14241 0710